



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн ТОГТООЛ

1961 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

дугаар 327

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотод морин
тээврийн баз байгуулах
тухай.

Б Н М А Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатар хотод байгуулагдах 300 морин тэрэгтэй морин тээврийн басыг өөрийн харьяа бөгийн авто тээврийн баз, худалдааны трестүүдийг үйлчлэх авто тээврийн басыг түшиглүүлж, хоёр тасаг болгон, энэ оны 9 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулахыг Улаанбаатар хотын ардын-депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н. БАТАА/-д зөвшөөрсүгэй.

2. Морин тээврийн базад шаардагдах хөрөнгийн тээврийн хянан үзэж, зохих хөрөнгийг Сайд нарын Зөвлөлийн бэлтгэл хөрөнгөнөөс Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд олгохыг Сангийн Яам /н. ДҮГЭРСҮРЭН/-д даалгасугай.

3. Морин тээврийн басын тасгуудын орон тоог хянан үзэж, батлаж өхийг Улсын орон тооны комисст даалгасугай.

4. Шинээр байгуулагдах морин тээврийн басын тасгуудад эрүүл бөгөөд эдэлгээнд сургагдсан, 5-6 насны, ажлын чадалтай эрлийз морь 80, монгол морь 100-ыг хотын ойролцоох сангийн аж ахуйнуудаас энэ оны 7 дугаар сарын 30-ны дотор шилжүүлэн өхийг Сангийн аж ахуйнуудыг удирдах газар /н. ЛООХУУЗ/-д даалгасугай.

5. Морин тээврийн басын тасгуудад тэрэгний гол төмөр-330 ширхэгийг энэ оны 7 дугаар сарын 30-ны дотор бэлтгэж өхийг Аж Үйлдвэрийн Яам /н. ДАМДИН/-д даалгасугай.

6. Морин тээврийн баазын тасгуудад шаардагдах 300 морин тэрэгний арал, тэнэг хэрэгсэл зэргийг энэ оны 8 дугаар сарын 1-ний дотор бэлтгэн, угсарч өхийг Үйлдвэрийн Хөршөөллын Төв Зөвлөл /н.ДЭМЧИГ/-т даалгасугай.

7. Морин тээврийн баазын тасгуудад зориулан, „Авто нефть импорт” нэгдэлд байгаа „ГАЗ-АА” машины резин дугуй 650 ширхэгийг зохих үнээр нь Улаанбаатар-хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд шилжүүлэн өхийг Гадаад Худалдааны Яам /н.ГОМБОЖАВ/-т даалгасугай.

8. Морин тээврийн баазын ачаа тээврийн хөлсний тарифийг боловсруулан батлаж, энэ оны 8 дугаар сарын 15-нээс мөрдүүлэхийг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н.БАТАА/-д даалгасугай.

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн 1-р орлогч дарга

МОЛОМЖАМЦ

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын 1-р орлогч дарга

ЦЭРЭНЖАВ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн
эрхлэгч



О.А.Дорж

/ДАГВАДОРЖ/